

Нийгмийн даатгалын ерөнхий газар

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2018.01.31.

№		Хөтөлбөрийн танилцуулга хэсэг
1	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
2	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө
4	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага
5	Хэрэгжих нийт хугацаа	6 жил
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг</b>		
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөлөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр		
4.1.1.1.5.	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	<p>Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээг улсын хэмжээнд онлайн системээр авахаар шийдвэрлэж програмтай холбоотой сургалтыг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулсан. Энэ програмаар хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөн болон цалингийн шатлал, зэрэг дэв, боловсролын байдал зэрэг мэдээллийг бүрэн гүйцэд оруулж өгснөөр тайлан мэдээ, судалгааг ил тод гаргах боломж бүрдэж байна.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалын 4 ажлын байрны сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлснээр Төрийн албаны зөвлөлөөс нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, шалгарсан иргэдийг ТАЗ-өөс нэр дэвшүүлсэн.</p>
4.1.1.2.1.	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Тус байгууллагын ажилтнуудын 75.8% нь 3-аас дээш жил, 50% нь 10-аас дээш жил ажиллаж байгаа бөгөөд туршлага, ур чадварыг үндэслэн мерит зарчмаар 10 орчим хувийг дэвшүүлэн ажиллуулж байгаа болно.
4.1.1.7.1.	Албан тушаалтанд холбогдох авлига,	Нийт 21 аймаг дүүрэгт ёс зүйн хороо байнгын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Тэтгэвэр

	<p>ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, харицлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>тогтоолт олголтын аянтай холбогдуулж, зөрчил гаргасан байцаагч нарыг ёс зүйн хорооны хурлаад оруулж, зөрчилтэй нь тогтоогдсон байцаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд анхан шатны байгууллагаас 2 төлөөлөл оролцуулж батлан ёс зүйн хорооны үйл ажиллагааг илүү нээлттэй болоход анхааран ажиллаж байна.</p>
4.1.1.9.1	<p>Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох</p>	<p>Иргэд даатгуулагчдад үйлчилгээг ойртуулах, түргэн шуурхай хүргэх зориулалтаар "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт", "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа", "Иргэн (Даатгуулагч)-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт", "Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт"-ын маягтуудыг ЭМНДЕГ-ын даргын 2017 оны А/41 тоот тушаалаар шинэчлэн батлууллаа. Мөн төрийн үйлчилгээний цахим машинаар лавлагаа, тодорхойлолтыг олгоход шаардлагатай вэб сервис програм хангамжийг боловсруулан Үндэсний Дата Төвд хүлээлгэн өгч, ашиглалтад орууллаа. Ингэснээр улсын хэмжээнд ашиглагдаж байгаа 109 төрийн үйлчилгээний цахим машинд иргэд даатгуулагч, ажил олгогч 2017 оны байдлаар 596.6 мянган удаагийн хандалт хийж, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар 83.4 мянган тодорхойлолт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 5.9 мянган лавлагаа, Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 0.5 мянган тодорхойлолт, Иргэн (Даатгуулагч)-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай 2.1 мянган тодорхойлолтыг хэвлэн авч үйлчлүүлсэн байна.</p>
<p>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p>		
4.1.2.1.1.	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн нэгтгэсэн мэдээнд шинжилгээ хийж, тоон мэдээллийг <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> вэб сайтад 12 удаа байршуулан мэдээллээр хангаж ажиллав.</p> <p>Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> цахим хуудасны мэдээллийн эргэлтийг сайжруулах, шинэчлэх чиглэлийн дагуу үйлчилгээний төрөл цэс дэх мэдээллүүдийг шинэчлэн боловсруулж оруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн даатгалын тухай ойлголт</li> <li>• Тэтгэврийн даатгал</li> <li>• Тэтгэмжийн даатгал</li> <li>• Ажилгүйдлийн даатгал</li> <li>• ҮОМШӨ-ний даатгал</li> <li>• Нэрийн данс</li> <li>• Сайн дурын даатгал</li> <li>• Гадаад улсад ажиллаж байгаа Монгол улсын иргэдийг нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах тухай</li> <li>• Лавлах цэсэнд байршиж буй Нийгмийн даатгалд хамрагдах, Нийгмийн даатгалын лавлагаа авах, шимтгэл төлөх дансны дугаар болоод холбоо барих утасны дугаарын мэдээлэл</li> <li>• Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын хаяг байршлыг тодорхой харагдах байдлаар google map хэлбэрээр оруулсан.</li> <li>• Төв орон нутгийн байгууллагууд цэсэнд аймаг дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын</li> </ul>



		<p>хэлтсийн Facebook хаягийг оруулах зэрэг ажлуудыг тогтмол байршуулан ажиллаж байна.</p> <p>Сумын байцаагчийг шаардлагатай програм хангамжаар хангаж, аймгийн ЭМНДХ-ийн ажилтнуудын ажлын ачааллыг хөнгөвчлөх зориулалт бүхий “Somweb” вэб програм хангамж шинээр нэвтрүүлснээр 300 гаруй сумын байцаагч тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн орлого, харилцах дансны мэдээллүүдийг сумандаа бүртгэлжүүлж, илгээх боломжтой болсон.</p> <p>Түүнчлэн сумдаас илгээсэн 4 төрлийн мэдээллийг ЭМНДХ дээрээ тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, харилцахын дансны дэд систем тус бүр дээр хөрвүүлэн импорт хийж авах өөрчлөлтийг холбогдох програм хангамжуудад бүрэн оруулж, нэвтрүүлсэн.</p> <p><b>2017 оны нэгдсэн мэдээллийн сангийн баяжуулалт</b></p> <p>Эрүүл мэнд, нийгмийн даатгалын салбарын 30 нэгжийн мэдээллийн санг <b>өдөр бүр цуглуулан нэгтгэж</b> нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажил тасралтгүй явагдаж байна. 2017 онд нийт 43.0 мянга гаруй ажил олгогч, 1.0 сая гаруй даатгуулагч, 1.0 сая гаруй эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцах иргэд, 380.0 мянга орчим тэтгэвэр авагч, бусад тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэд даатгуулагчдын дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан 45GB өгөгдөл цуглуулж, 60GB өгөгдөл мэдээллийг нөөцөлж хадгаллаа.</p> <p>Мэдээллийн санг өдөр тутам цуглуулан нэгтгэснээр нийгмийн даатгалын цахим үйлчилгээний дараах үр дүнгүүд гарч байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн байгууллагууд гэрээнд заагдсан мэдээллүүдээ вэб сервисээр өдөр тутам шинэчлэн авах, харах;</li> <li>- Иргэд /даатгуулагч/ шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал олголтын мэдээллээ тухай бүр цахимаар шинэчлэн авах;</li> <li>- Иргэд /даатгуулагч/ шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтоо Төрийн үйлчилгээний цахим машинаас тухай бүр шинэчлэн авах;</li> <li>- Улсын хэмжээний 1000 орчим эмнэлэг, эмийн сан, эрүүл мэндийн байгууллагууд үйлчлүүлж буй иргэд даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан мэдээллийг цахимаар өдөр тутам хянах;</li> <li>- ЭМНД-ын байгууллагуудын ажилтнуудын албан ажлынхаа хүрээнд даатгуулагч болон ажил олгогчийн шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт олголт, шимтгэлийн өр авлагын зэрэг 26 мэдээллийг тухай бүр шинэчлэн харах хянах;</li> </ul> <p>Түүнчлэн 43.0 мянга гаруй ажил олгогч, 610 гаруй эмнэлэг, 360 гаруй эмийн сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн даатгуулагчдын мэдээллийг цахимаар хүлээн авч, нэгдсэн мэдээллийн санд оруулах, хянан баталгаажуулах ажил тогтмол хийгдэж байна.</p>
4.1.2.1.2.	Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	<p>Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдэлтэй нийт 1.4 сая даатгуулагчийн 2016 оны эцсийн үлдэгдлийг Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2016.05.17-ны өдрийн 17 тоот “Нэрийн дансны 2016 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ” тогтоолоор баталсан хүүгээр өсгөн шинэчлэн тооцлоо. Шинэчилсэн эцсийн үлдэгдлийг төв орон нутгийн ЭМНД-ын байгууллагад ашиглагдаж байгаа нэрийн дансны бүртгэлийн вэб програм хангамжид суурилуулж, даатгуулагчаар болон ажил олгогчийн нийт дүнгээр харах, хэвлэх боломжийг бүрдүүлсэн. Мөн нэрийн дансны мэдээллийн санг Үндэсний дата төвд байршуулж, Төрийн үйлчилгээний цахим машинаас тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээллээ хэвлэн авах боломжийг бүрдүүлснээр 2017 онд 5.9 мянган даатгуулагч мэдээллээ авсан</p>

		байна. Түүнчлэн “Шимтгэл төлөлт, нэрийн дансны цахим мэдээлэл” цахим системд шинэчилсэн мэдээллийн санг холбож, иргэд даатгуулагч нэрийн дансны үлдэгдлээ өөрийн имэйл хаяг руу авах боломжийг бүрдүүлээ.
4.1.2.4.3.	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2017 онд тус газраас хийсэн хяналт шалгалтын 100 хувь нь дотооддоо хийсэн шалгалт байсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны “Аян эхлүүлэх тухай” А/319 дүгээр тушаалаар баталсан удирдамжаар “Тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах аян”-ыг 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд 2 үе шаттайгаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/11 дүгээр тушаалаар аян зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, “Тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах аян” (цаашид “Аян” гэх)-ыг 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, нийт 381,5 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн тогтоолт, олголтыг баталгаажуулж дууслаа. Аян зохион байгуулах гол үндэслэл шаардлага нь нэгдүгээрт тэтгэвэр авагчдаас тэтгэврийн тогтоолтоо шалгуулахаар эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудад удаа дараа ирүүлж байгаа өргөдөл, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх, хоёрдугаарт аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагууд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн зарим зүйл заалтыг нэгдсэн чиглэл, нэг ойлголтоор хэрэгжүүлэх шаардлага, гуравдугаарт Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл, бэрхшээл хууль тогтоомжтой нийцүүлэн гарсан аргачлал, зөвлөмжийн зөрүүтэй байдлыг нэг мөр шийдвэрлэх, аймаг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хийгдэхдотоодын хяналт шалгалтыг цөөрүүлж, цаашид тогтоогдох тэтгэвэр, тэтгэмжид гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ байлаа.
4.1.2.7.1.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын гэрчилгээ, дүгнэлт, Шилэн дансны хуулийн хүрээнд нийтэд мэдээлэх төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдлын мэдээллүүдийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд хуулийн хугацаанд нь тогтмол байршуулан мэдээллээр хангаж ажиллав. Салбарын хэмжээнд төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаарх шилэн дансанд байршуулвал зохих 7104 мэдээ байгаагаас хуулийн дагуу байршуулсан 6930 мэдээ байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээлэл 2017 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар 98 хувьд хүрээд байна.
Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр		
4.1.7.1.1.	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9001 стандартын 10 дугаар бүлгийн “Байгууллага үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг сайжруулах боломжийг тодорхойлох, сонгох, бүтээгдэхүүн, үйлчилгээг эрэлт, хэрэгцээ, хүлээлтэд нийцэхээр сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэл, үр бүтээлтэй байдлыг сайжруулах” шаардлагын дагуу нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэн, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх тасралтгүй сайжруулалтыг хийх зорилгоор Баянгол, Багануур дүүрэг, Дорнод, Хөвсгөл аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Нийгмийн даатгалын үйлчилгээний тасгийн тэтгэвэр тогтоох, олгох одоогийн үйл ажиллагааны үйл явц (процесс зураглал)-ыг өөрчлөн зохион байгуулах,



		<p>тэтгэврийн байцаагч ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн турших ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай эхлүүлж, туршилтын ажлын үр дүн, давуу болон сул тал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2018 оноос эхлэн нийт аймаг, дүүргийн хэлтсүүдэд нэвтрүүлэхээр шийдвэрлэлээ.</p> <p>Туршилтын ажлын үр дүнд тэтгэвэр тогтоолт, олголтод тавих хяналт сайжирч, тэтгэвэр тогтоож, олгоход зарцуулах хугацаа багасах, ажил үйлчилгээний шат болгонд тухайн ажлыг хариуцах ажилтнуудын ажлын хариуцлага, хяналт, мэргэжлийн ур чадвар сайжрахаас гадна улмаар тэтгэвэр авагч иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ гэж үзэж байна.</p>
<p>Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p>		
4.1.10.1.4.	<p>Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах</p>	<p>Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хуулийн хэрэгжилт”-ийн талаар 5 удаагийн сургалт зохион байгуулж, 253 албан хаагчид оролцов.</p> <p>Шинэ ажилтнуудад зориулсан цахим сургалтад нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах, мэдүүлэг тайлбар гаргах талаар оруулж, сургалтыг аймаг, нийслэл, дүүргийн ажилтнуудад тухай бүр танилцуулж байна. Байгууллагын цахим сүлжээнд Азийн сангаас гаргасан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”-г байршуулж, яриа хэлэлцүүлэг өрнүүлэх чиглэлийг орон нутгийн ЭБАТ-дад өгснөөр орон нутагт яриа, хэлэлцүүлэг, уралдаан зохиох зэрэг ажлуудыг зохион байгуулсан.</p>

Танилцсан: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга

Төлөвлөгөөний биелэлт гаргасан: Тамгын газрын Хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн, ЭБАТ



Д.Зоригт

Г.Сурахбаяр